

## **БАЯНХОНГОР АЙМГИЙН 2015 ОНЫ 2 ДУГААР САРЫН ТАНИЛЦУУЛГА**

### **ТӨСӨВ, МӨНГӨ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ**

2015 оны 2 дугаар сард аймгийн төсвийн орлогын дүн 925.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 117 сая төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн байна. 2015 оны 2 сард нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баянхонгор, Шинэжинст, Богд, Өлзийт, Бууцагаан сумаас бусад сумууд биелүүлээгүй байна.

Аймгийн нийт орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14.5 хувь, орон нутгийн нийт орлого 28.9 хувиар өссөн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: ЦХТА орлого 161.9 сая төгрөг, ИОТТХ 3.6 сая төгрөг, патент 1.5 сая төгрөг, хог хаягдлын хураамж 14.6 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 1.5 сая төгрөгөөр тасарч бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ орлогын албан татвар 3.2 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.4 хувь, агаарын бохирдол 1.0 хувь, ашигт малтмал 1.2 хувь, ҮХЭХ-ийн татвар 0.2 хувь, ЦХТА орлого 66.3 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 0.3 хувь, хүү торгууль 6.6 хувь бусад төлбөр хураамж 14.8 хувийг эзэлж байна.

#### **2015 оны 02 - р сарын мэдээ / өссөн дүнгээр, мян.төг/**

	Үзүүлэлт	2015 оны 02 - р сар		ТБ хувь
		төл	гүйц	
1	Нийт орлого	1058195	925529.2	87.5
	Нэг.Татварын орлого	1058195	924541.2	87.4
	А. Төрийн сан орлого	100405.0	108147.9	107.7
	1.ААНБ-н орлогын татвар	23000.0	29179.1	127
	2. НӨАТатвар	76000.0	59344.4	78
	3.Онцгойн татвар	0.0	0.0	0
	4. Агаарын бохирдол /Авто/	1400.0	331.9	24
	5. Агаарын бохирдол /нүүрс/	0.0	8538.9	0
	6.Ашигт малтмал	5.0	10753.6	215072
	Орон нутаг нийт дүн	957790.0	816393.3	85
	Б.Орон нутаг дүн	788000.0	632550.8	80
	а.ЦХТА орлого /Суутган-1/	776000.0	614011.2	79
	АТӨЯХ-н татвар	0.0	2956.3	0
	ҮХЭХ-ийн татвар	0.0	1912.8	0
	б.Газрын төлбөр	12000.0	13670.5	0
	В.Орон нутаг дүн	169790.0	183842.5	108
	1.Хүн амын орлого	35940.0	30863.9	85.9
	а.Мал бүхий иргэний орлого	0.0	0.0	0
	б.ИОТТ	32200.0	28579.9	88.8
	в.Патент	3740.0	2284.0	61.1
	2.ҮХЭХ борлуулсны	8000.0	13435.0	167.9
	3.Бууны татвар	0.0	296.5	0
	4.Бусад төлбөр хураамж	69040.0	77975.1	112.9
	а.Улсын тэмдэгтийн хураамж	27040.0	25499.8	94.3
	б.Газрын төлбөр	0.0	576.8	0
	в.Газрын дуудлага худалдаа	0.0	0.0	0
	г.Хог хаягдлын хураамж	42000.0	27387.0	65.2
	д.Ус ашигласны төлбөр	0.0	1526.1	0
	е.Рашаан ашигласны төлбөр	0.0	0.0	0
	ё.Түгээмэл тархацтай АМАТ	0.0	0.0	0
	ж.Ойгоос мод, түлээ бэлтгэж АТ	0.0	0.0	0
	з.Агнуурын нөөц ашигласны	0.0	22940.0	0
	5.Хүү торгууль	56810.0	61272.2	107.9

Хоёр. ТБӨОрлого	0.0	988.0	0
-----------------	-----	-------	---

2 дугаар сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 44561.4 сая төгрөгт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 122614.4 сая төгрөгт хүрчээ.

Чанаргүй зээл 652.1 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байна.

**Аймгийн банкуудын Мөнгө зээлийн  
2015 оны 2-р сарын мэдээ  
/мян.төг/**

	2 ДУГААР САР		2015.2/ /2014.2
	2014	2015	
Зээлийн өрийн үлдэгдэл	103407088.1	122614418.33	118.6
Аж ахуйн нэгжийн төрлөөр:Улсын байгууллага			
Хувийн хэвшилд	3698919.2	6091337.5	164.7
Бусад	99672364.9	116523080.84	116.9
Хугацаа хэтэрсэн	333662.0	1376159.77	412.4
Чанаргүй зээл	519091.4	652116.39	125.6
Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	39424868.0	44561393.59	113.0
Зээлийн хүү дээд доод хязгаар / хувиар/	0.6-3.0	0.5-2.5	0.0
Хадгаламжийн хүүний дээд доод хязгаар/жилээр/	3.6-16.2	3.6-16.2	0.0
Харилцахын үлдэгдэл	8979067.9	7103952.8	79.1

**ХӨДӨӨ АЖ АХУЙ**

2015 оны 2 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээгээр 1367 том мал зүй бусаар хорогдсон байна. Нийт хорогдлын 66.7 хувь нь Богд, Бууцагаан, Өлзийт сумдад гарчээ. Баянлиг, Хүрээмарал, Баацагаан Баянцагаан, Баян-Овоо, Жинст Шинэжинст, Бөмбөгөр сумууд эхний 2 сарын байдлаар хорогдолгүй байна.

Хорогдсон малыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 597 мал буюу 30.4 хувиар буурсан.

**Хорогдсон том мал**

Сум/дүүрэг	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Баянхонгор	82	0	0	6	34	42	0	0	0	0	0.1	0
Баянбулаг	108	0	6	11	36	55	0.1	0	0.2	0.2	0.1	0.2
Баянговь	47	1	0	0	5	41	0.1	0.1	0	0	0.1	0.1
Баян-Өндөр	19	0	0	0	4	15	0	0	0	0	0.1	0
Богд	246	9	11	20	33	173	0.1	0.2	0.2	0.4	0.1	0.1
Бууцагаан	522	0	0	4	117	401	0.2	0	0	0.1	0.2	0.2
Галуут	103	0	23	16	25	39	0.1	0	0.2	0.1	0	0.1
Гурванбулаг	38	0	1	8	7	22	0	0	0	0.1	0	0.1
Жаргалант	1	0	0	1	0	0	0	0	0	0	0	0
Заг сум	37	0	1	3	6	27	0	0	0	0	0	0.1
Өлзийт сум	144	0	0	0	29	115	0.1	0	0	0	0.1	0.1
Эрдэнэцогт	20	0	4	5	7	4	0	0	0.1	0	0	0
	<b>1367</b>	<b>10</b>	<b>46</b>	<b>74</b>	<b>303</b>	<b>934</b>	<b>0.7</b>	<b>0.3</b>	<b>0.7</b>	<b>0.9</b>	<b>0.8</b>	<b>1</b>

### **ЭРҮҮЛ МЭНД**

2015 оны 2 сарын байдлаар аймгийн хэмжээнд 342 хүүхэд төрсөн ба үүнээс сумдаас аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж төрсөн 159 хүүхэд байна. Төрсөн хүүхдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25 хүүхдээр бага байна.

Архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн онтой харьцуулахад сүрьеэ 1, салхин цэцэг 16, тэмбүү 19, арьсны мөөгөнцөр 20, трихоминиаз 23, бруцеллөз 2 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2 сард нас баралтын 82 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс эмнэлэгт нас баралт 32.9 хувийг эзэлж байна.

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны 2 сард 3149 байсан бол энэ оны 2 сард 2819 болж 330 дуудлага буюу 10.5 хувиар буурсан байна

### **АЖ ҮЙЛДВЭР**

2015 оны 2 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 973477.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 58231.2 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урьд оны мөн үеэс дулаан 5.9 мян.Гкал-р, нарийн боов 1.9 тн-оор, талх 5.2 тн-оор, хэвийн боов 3.6 тн-оор тус тус өсч, бусад бүтээгдэхүүнүүд буурсан байна.

#### **Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/**

	Нэгдүгээр сар		
	2014	2015	$\frac{2015.02}{2014.02}$
Нийт борлуулалт	915246.3	973477.5	106.4

#### **Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/**

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Хоёрдугаар сар		
		2014	2015	$\frac{2015.02}{2014.02}$
Дулааны эрчим хүч	мян.Гкал	46.3	52.2	113.4
Нарийн боов	тн	6.6	8.5	128.8
Талх	тн	5.8	11.0	189.6
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	48	39.4	82.1
Хэвийн боов	тн	2.2	5.8	263.6
Нүүрс	мян.тн	10.6	8.8	83.0

### **НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ**

2015 оны 2 дүгээр сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 3241.1 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 660.4 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 232.7 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 61.6 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 3.0 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 109.7 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 39.7 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 4.8 сая төгрөг, тэжээгчээ алдсаны

тэтгэвэр 7.1 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 28.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 497.8 сая төгрөг олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 2015 оны 2 сард 6582 хүнд 828.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.2015 оны 2 сард Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 8613 иргэнд 821.5 сая төгрөгийн хөнгөлөлт, мөнгөн тусламж, 231 ахмадад 17.7 сая төгрөгийн нэг удаагийн хөнгөлөлт тусламж, хөгжлийн бэрхшээлтэй 103 иргэнд 13.9 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж олгожээ.

**Нийгмийн даатгалын сангийн 2-р сарын мэдээ /өссөн дүнгээр мян.төг/**

Үзүүлэлт	2015 оны 02 - р сар		ТБ хувь
	төлөвлөгөө	гүйцэтгэл	
<b>Тэтгэврийн даатгалын сангийн зарлагын дүн:</b>	4127920.95	6733497.76	163.1
Үүнээс:Өндөр насны тэтгэвэр	3099724.67	3241142.60	104.6
Тахир дутуугийн тэтгэвэр	476563.83	660386.78	138.6
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	408442.29	232701.76	56.9
Цэргийн тэтгэвэр	75391.96	61601.16	81.7
<b>Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын дүн</b>	177277.6	185534.89	104.6
Үүнээс:Хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмж	7412.88	2967.05	40.0
Жирэмсэн амарсны тэтгэмж	124850.49	109709.16	87.9
Оршуулгын тэтгэмж	37237.63	39719.95	106.7
<b>ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлагын дүн</b>	26171.37	37458.63	143.1
Үүнээс:Тахир дутуугийн тэтгэвэрт	10143.81	4838.85	47.7
Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	4550.87	7055.27	155.0
<b>Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын дүн</b>	32974.04	51654.58	156.6
Үүнээс:Ажилгүйдлийн тэтгэмж	29158.64	28539.73	97.9
<b>Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын дүн</b>	690552.13	649372.87	94.0
Үүнээс:Эмчилгээний эмийн зардал	594421.78	497779.42	83.7
Рашаан сувилалын зардал	0.0	60000.0	0
Эмийн үнийн хөнгөлөлт	73911.50	15985.88	21.6

**Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ / төрлөөр, 2015 оны 02 сарын байдлаар/**

Үзүүлэлт	2015 оны 02 дугаар сар	
	хамрагдсан хүний тоо	олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян.төг/
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж</b>	6582	828152.3
<b>Халамжийн тэтгэвэр</b>	2076	463827.85
<b>Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	4506	364324.45
Үүнээс: Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	2782	166085.07
Ахмад настныг асарч буй иргэний	662	64333.74
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний	395	40718.32
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний тэтгэмж	61	5679.52

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлсэн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тэтгэмж	8613	821520.0
Ахмад настуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	231	17751.46
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	103	13883.25
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	16	5397.0

### **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО**

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2015 оны 2 дугаар сарын эцэст 682 болж, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 63.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзэхэд 0.9 хувь нь магистр, доктор, 22.4 хувь нь дипломын болон бакалаврын, 5.7 хувь нь тусгай мэргэжлийн, 7.8 хувь нь техникийн мэргэжлийн, 37.4 хувь нь бүрэн дунд, 18.6 хувь нь бүрэн бус дунд, 5.4 хувь нь бага боловсролтой, 1.8 хувь нь боловсролгүй хүмүүс байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг нь насны бүлгээр нь судлахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн 20.8 хувийг 15-24 насныхан, 39.6 хувийг 25-34 насныхан, 23.3 хувийг 35-44 насныхан, 15.9 хувийг 45-59 насныхан, 0.4 хувийг 60 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. 2015 оны 2 сард бүртгэлтэй ажилгүй иргэдээс 30 хүн ажилд зуучлагдан орсон 40 хувь нь боловсруулах үйлдвэрлэлд, 60 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт ажилд зуучлагдан оржээ.

#### **Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн / насны бүлгээр, 2015 оны 02 дугаар сард/**

Үзүүлэлт		2015.02
Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүний тоо Бүгд		30
Үүнээс: эмэгтэй		15
Насны бүлгээр	15-24	2
	Эмэгтэй	1
	25-34	6
	Эмэгтэй	3
	35-44	11
	Эмэгтэй	6
	45-54	10
	Эмэгтэй	5
	55-59	1
	Эмэгтэй	0
Ажил мэргэжлийн ангиллаар	Менежер	1
	Эмэгтэй	0
	Мэргэжилтэн	2
	Эмэгтэй	2
	техникч болон туслах /дэд мэргэжилтэн	6
	Эмэгтэй	2
	Контор үйлчилгээний ажилтан	1
	Эмэгтэй	0
	Худалдаа үйлчилгээний ажилтан	9
	Эмэгтэй	9

ХАА, ой,загас агнуурын ажилтан	2
Эмэгтэй	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	8
Эмэгтэй	2
Суурин төхөөрөмж,машин механизмын операторч,угсрагч	1
Эмэгтэй	0
Энгийн ажил мэргэжил	0
Эмэгтэй	0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	0
Эмэгтэй	0

**Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн / эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2015 оны 02 дугаар сард/**

Үзүүлэлт		2014.02
Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүний тоо Бүгд		30
Үүнээс: эмэгтэй		15
Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	ХАА, ойн аж ахуй,загас барилт, ан агнуур	5
	Уул уурхай олборлолт	0
	Боловсруулах үйлдвэрлэл	12
	Цахилгаан хий, уур агааржуулалт	0
	Усны хангамж,бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0
	Барилга	0
	Бөөний болон жижиглэн худалдаа,машин мотоциклийн засвар үйлчилгээ	7
	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0
	Зочид буудал,байр,сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0
	Мэдээлэл холбоо	0
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0
	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0
	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0
	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын даатгал	1
	Боловсрол	0
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0
	Урлаг, үзвэр,тоглоом наадам	0
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5
Хүн хөлслөн ажиллуулдагөрхийн үйл ажиллагаа	0	
Олон улсын байгууллага,суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	

**Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо / насны бүлгээр, 2015 оны 02 дугаар сарын эцэст/**

Үзүүлэлт	2015.02
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо Бүгд	682
Үүнээс: эмэгтэй	432

Насны бүлгээр	15-24	142
	эмэгтэй	97
	25-34	270
	эмэгтэй	175
	35-44	159
	эмэгтэй	94
	45+	111
	эмэгтэй	66
Боловсролын түвшингээр	Магистр, доктор	6
	эмэгтэй	4
	Дипломын болон бакалаврын	153
	эмэгтэй	126
	Тусгай мэргэжлийн	39
	эмэгтэй	24
	Техникийн	53
	эмэгтэй	22
	Бүрэн дунд	255
	эмэгтэй	157
	суурь	127
	эмэгтэй	67
	Бага	37
	эмэгтэй	26
	Боловсролгүй	12
	эмэгтэй	6

### ГЭМТ ХЭРЭГ

2015 оны 2 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 84 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 20 хувиар өсч, бүх гэмт хэргийн 46.4 хувийг хөнгөн, 45.2 хувийг хүндэвтэр, 4.8 хувийг хүнд, 3.6 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэрэг зөрчлийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 79.2 сая төгрөгийн хохирол учирч, 37.7 сая төгрөгийн хохиролыг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 93 хүн холбогдогдсоны 5.4 хувь нь 14-17 насны хүүхэд, 94.6 хувь нь 18-аас дээш насныхан холбогдсон байна. Нийт гэмт хэргийн 54.8 хувь нь Баянхонгор суманд, 45.2 хувь нь бусад сумдад үйлдэгдсэн байна.

#### Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо / хэргийн ангиллаар, жил бүрийн 02 сарын байдлаар /

д/д	Үзүүлэлт	02 дугаар сар		тайлант/өмнөх оны мөн үе
		2014	2015	
1	<b>Нийт гэмт хэрэг</b>	70	84	120
	Үүнээс: Хөнгөн	28	39	139.3
	Хүндэвтэр	36	38	105.5
	Хүнд	4	4	100
	Онц хүнд	2	3	150
2	<b>Учирсан хохирол / сая төг/</b>	67.1	81.9	122.1
	Иргэд ба аж ахуйн нэгж	67.1	79.2	118.5

	Төрийн болон гадаадын ХХО-өмчид			
	Нөхөн төлүүлсэн	38.6	37.7	97.7
3	<b>Нийт холбогдогч</b>	81	93	114.8
	14-17 нас	5	5	100
	18-аас дээш	76	88	115.8
	Эмэгтэй	6	10	166.7

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сумаар/**

д/д	Сумын нэр	02 дугаар сар		тайлант/өмнөх оны мөн үе
		2014	2015	
1	Галуут	3	1	33.3
2	Баян-Овоо	3	7	233.3
3	Эрдэнэцогт	3	3	100
4	Өлзийт	0	7	0
5	Жинст	4	3	75
6	Богд	0	1	0
7	Баянлиг	0	0	0
8	Баянговь	1	1	100
9	Шинэжинст	0	1	0
10	Баян-Өндөр	0	1	0
11	Баянцагаан	1	0	0
12	Баацагаан	3	1	33.3
13	Бөмбөгөр	7	4	57.1
14	Бууцагаан	2	0	0
15	Хүрээмарал	0	1	0
16	Баянбулаг	0	1	0
17	Гурванбулаг	0	1	0
18	Заг	2	2	100
19	Жаргалант	1	3	300
20	Баянхонгор	40	46	115
	<b>ДҮН</b>	<b>70</b>	<b>84</b>	<b>120</b>

**ҮНЭ**

2015 оны 2-р сарын байдлаар инфляци өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар өсчээ. Инфляци өсөхөд голлож гурил, мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны үнэ болон цэвэр, бохир ус болон цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэн нь голлож нөлөөлсөн байна

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, 2 дугаар сард, суурь онтой харьцуулснаар

хувь percentage

Аймаг, нийслэл	Ерөнхий индекс	Хүнсний бараа, ундаа ус	Согтууруулах ундаа, тамхи	Хувцас бес бараа, гутал	Орон сууц, ус, цахилгаан, түлш	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	Тээвэр	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	Бусад бараа, үйлчилгээ
Баянхонгор	170.1	160.0	227.6	222.0	125.0	239.8	126.5	132.6	95.1	81.8	230.0	198.6	138.4

2010 он суурь он

